

АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга	1
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	12
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	13
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	14
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
7. Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө	21
8. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
11. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	25
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	27
14. Төсөв зардлын тооцоо	27

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл :

Төслийн нэр: “Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай-Нарийнсухайт чиглэлийн автозамтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч:

- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Жавхлант-Орд ХХК
- Улсын бүртгэлийн дугаар: 9019058049
- Регистрийн дугаар: 5217652
- Хаяг: Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 26, Их хуралдай бизнес төвийн 1004 тоот
- Холбоо барих утас: 77111101
- Цахим хаяг: javkhlantord@gmail.com

1.2 Төслийн үндэслэл:

Нүүрсний уурхайгаас Шивээхүрэнгийн боомт хүртэлх 92.3 км замаар экспортын тээвэр хийж байна. Энэхүү замын Баянтолгой уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай- Нарийн сухайт чиглэлийн авто замтай холбогдох хэсгийн 17,9 км замыг хатуу хучилттай болгосноор хөрсний элэгдэл эвдрэл, тоосжилт зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах ач холбогдолтой.

1.3 Төслийн зорилго:

Төсөл хэрэгжүүлэгчийн үндсэн бүтээгдэхүүн болох нүүрсийг тээвэрлэх хэрэгсэл, бусад тээврийн хэрэгслийн саадгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх, тээврийн үйл ажиллагааг аюулгүй, байгаль орчинд сөрөг нөлөө багатай байлгах, стандарт шаардлага хангасан хүнд даацын авто замыг инженерийн байгууламжийн хамт барьж ашиглалтанд оруулахад төслийн зорилго оршино.

1.4 Төсөл хэрэгжих талбайн байршил:

Эхлэх цэг: Өмнөговь аймгийн Баясах багийн нутагт орших MV-016952 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Жавхлант-Орд” ХХК-ний Баянтолгой нүүрсний уурхай / X=691317.54 ; Y=4796239.82/-аас эхэлнэ.

Төгсөх цэг: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Хотгорын нүүрсний уурхай- Нарийн сухайт чиглэлийн авто зам / X=683913.00; Y=4780208.00/-тай холбогдоно.


Төслийн хүрээнд баригдах 17.9 км авто замын трассын солбицлын цэгүүдийг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1 : Баянтолгой нүүрсний уурхайгаас эхлэн Хотгорын нүүрсний уурхий Нарийнсухайт чиглэлийн авто зам хүртэл 17.9 км авто замын трассын солбицлын цэгүүд

№	Байрлал	X	Y
1	Эхлэл 0+000	691317.50	4796239.82
2	1+000	690866.00	4795347.55
3	2+000	690414.49	4794455.28
4	3+000	689963.67	4793562.68
5	4+000	689655.99	4792611.50
6	5+000	689355.58	4791657.69

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

7	6+000	689062.95	4790701.78
8	7+000	688953.15	4789707.89
9	8+000	688776.21	4788726.93
10	9+000	688498.42	4787766.29
11	10+000	688019.38	4786912.64
12	11+000	687353.89	4786166.23
13	12+ 000	686956.23	4785251.54
14	13+000	686457.07	4784387.80
15	14+000	685934.83	4783535.55
16	15+000	685478.11	4787646.10
17	16+000	684835.17	4781880.74
18	17+000	684339.57	4781015.01
	Төгсгөл: 17+912	683913.00	4780208.00




1.5 Төслийн үйл ажиллагааны танилцуулга:

Уулзваруудын төлөвлөлт

Төслийн төлөвлөгдөж буй зам нь орон нутгийн байгалийн хөрсөн замуудтай огтлолцох ба цаашлаад шинээр бий болох уурхайнууд, ойролцоох сум, багийн төвүүдээс ирсэн туслах замуудаас төслийн зам руу орох, хөндлөн гарах зэрэг томоохон уулзвар огтлолцлыг авто зам төсөллөх БНБД 32-01-07 дүрмийн дагуу туслах замыг уулзвараас 100 м хүртэл урт хэсэгт хучилттай байх, уулзвар дээрх эргэлтийн радиусыг 30 м-ээс багагүй байх, бүх уулзварууд дээр хурд шилжүүлэх зурвасын нийт урт нь 125 м, бүрэн өргөнтэй зурвас нь 65 м, хурд шилжүүлэх зурвасын өргөн 3.5 м байхаар төлөвлөсөн байна.

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1: Төлөвлөсөн уулзвар

Авто замын хийцийн төлөвлөлт

Далан ухмал : Далангийн зөвшөөрөгдөх хамгийн бага өндөр болон гүний усны түвшнээс дээш хучилтын өргөгдөх хэмжээний үзүүлэлт болон бусад шаардлагатай үзүүлэлтүүдийг "Авто зам төсөллөх" БНБД 32-01-07 ба Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл БНБД 23-03-04 стандартын шалгуур үзүүлэлтүүдийг хангахуйцаар ТЭЗҮ-д тооцож төлөвлөсөн байна. Төслийн авто зам газар хөдлөлтийн идэвх багатай бүсээр дайран өнгөрнө. Төслийн авто зам дайран өнгөрөх бүс нутаг газар хөдлөлтөөрөө Рихтерийн 9 баллаас ихгүй тул тусгайлсан шийдэл шаардахгүй байна.

Хөндлөн огтлолын хэмжээ

Төслийн авто замаар овор ихтэй хүнд даацын автомашин зорчих бөгөөд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан төлөвлөлтийг хийх шаардлагатай. Иймээс БНБД 32-01-07-ийн 4.5-д заасны дагуу сонгогдсон 3-р зэргийн замын өргөнийг доор дурдсан байдлаар төсөвлөв. Үүнд:

- I. Хөдөлгөөний нэг зурвасын өргөн нь 3.5 м. 2 зурваст зам тул 3.5x3.5 нийт 7.0м
- II. Хөвөөний өргөн 2x2 нийт 4 м, хучлага бэхэлгээтэй хөвөө 0.5 м байна.

Амрах талбай

Авто зам төсөллөх стандартын дагуу гол замын дагуу байрлах амрах талбайд дараах үйлчилгээний цэгүүдээс бүгдийг эсвэл заримыг нь заавал байлгах ёстой. Үүнд: бүх төрлийн тээврийн хэрэгслийн зогсоол, ундны усны эх үүсвэр, хоолны ширээ сандал бүхий саравч, автомат телефон утас, лавлах - мэдээллийн цэг, гэрэлтүүлэг болон бусад төрлийн үйлчилгээний цэг зэрэг багтана.

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Авто замын хэвтээ болон дагуу эргэлтүүдийн норм

Трассын нормууд нь тооцоот хурднаас хамаардаг. Доорх хүснэгтэнд төслийн замын хэвтээ төлөвлөлт болон дагуу огтлолын утгуудыг харууллаа.


Хүснэгт 2: Төслийн замын тэнхлэгийн авто замын техникийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Нэгж	Тооцоот үзүүлэлтүүд		
			Тал газар	Хэрчигдсэн газар	Уулархаг газар
1	Тооцоот хурд	км/ц	80	60	50
2	Зурвасын өргөн	м	3.5		
3	Хөвөөний өргөн	м	2.0		
4	Зорчих хэсгийн хэвгий	%	20		
5	Хөвөөний хэвгий	%	40		
6	Хучилтын төрөл		Цемент бетон хучилт		
7	Тоормослох зурвасын урт	м	140	85	65
8	Эргэц дээрх зорчих хэсгийн хэвгийн хамгийн бага угта	%	60		
9	Хэвтээ муруйн хамгийн бага радиус	м	1300	900	600
10	Шилжилтийн муруйн зөвшөөрөгдөх хамгийн бага урт	м	100	100	120
11	Эргэцийн дагуу налуугийн хамгийн их хэмжээ	%	60		
12	Эргэцийн муруйн хамгийн бага радиус	м	250	150	150
13	Зөвшөөрөгдөх хамгийн их дагуу налуу	%	60	70	80
14	Далангийн хажуу налуугийн хамгийн их хэмжээ		Далангийн өндөр, хөрсний төрлөөс хамаарна.		

Тооцоот хурданд III зэргийн замыг сонгосон бөгөөд зурвасын өргөн 3.5 м, хөвөөний өргөн 2 м, зорчих хэсгийн хэвгийг 20%, хөвөөний хэвгийг 40% байхаар төлөвлөсөн байна.

Замын хучилт төлөвлөлт

Төлөвлөж буйгаар хоногт Монгол улсаас БНХАУ-руу тус бүрдээ 80 тн-ын нүүрс ачсан хүнд даацын 79 ачааны машин, БНХАУ-аас Монгол улс руу ачаагүй хоосон тэвштэй хүнд даацын 79 ачааны машин авто замын хөдөлгөөнд оролцоно гэж үзсэн байна. Энэ хөдөлгөөний эрчмээс хамааран төлөвлөж буй авто замын хучилтын хийцийн 3 хувилбар гаргасан бөгөөд 1-р хувилбарыг сонгосон.



Зураг 2: Хучилтын хийцийн 1-р хувилбар

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хиймэл байгууламжийн төлөвлөлт

Гүүр хоолой: Энэхүү төслөөр баригдах гүүр хоолойн болон бусад үс зайлуулах хиймэл байгууламжийн зураг төслийг "Авто замын гүүр хоолой төсөллөх" БНБД 32.02.03 шаардлагад тулгуурласан бөгөөд төслийн замаар 80-100 тн хүнд даацын тээврийн хэрэгсэл голлон зорчих учир АASHTO стандартын HS20 ачаалалд тооцоолж хүчитгэсэн төмөр бетон хийцүүдийг төлөвлөсөн байна.

Уг замын төсөл нь байгаль цаг уурын хувьд хур бороо багатай говь цөлийн хуурай уур амьсгалтай бүсэд хамаарагдах бөгөөд газрын гадаргуу нь тэгш тал учир жилд цөөн болох үер нь эрчим багатай жилийн ихэнх хугацаанд хуурай байх тул ус зайлуулах хиймэл байгууламжийг сонгохдоо усны тооцоонд үндэслэн давуулах далан, дугуй болон тэгш өнцөгт хэлбэрийн хоолойг сонгон төлөвлөсөн.

Төслийн сонгосон трасст урьдчилан тооцоолсноор трассын эхлэлийн эхний 10 км орчимд 5-6 байрлалд давуулах далан төлөвлөгдөх шаардлагатай хуурай өргөн сайрууд байна. Авто замын ус нэвтрүүлэх дугуй, тэгш өнцөгт болон дөрвөлжин хэлбэрийн төмөр бетонон хоолойн ёроолыг критик хэвгийтэй тэнцүү ба их байхаар сонгоно. Төлөвлөсөн авто замын ус нэвтрүүлэх байгууламжийн гидравлик тооцоог түрэлтгүй ус нэвтрүүлэх хоолойн зарчмаар тооцож авто зам доогуур үерийн урсац өнгөрөөх барилга байгууламж нийт 60 байршилд тооцсон бөгөөд дараах хийцүүдтэй байна. Үүнд:


- 100-200 м давуулах далан
- Хоолойн төрөл Ф1х1.0
- 2х2.5м хүртэл дөрвөлжин огтлол төмөр бетон хоолой

Ус зайлуулах хэсэг

Хучилтаас ус зайлуулах хэсэгт хур тунадасны усыг хучилтын гадаргуугаас хучилтын хөндлөн хэвгийгээр урсгаж ус зайлуулахаар төлөвлөж 20% налуутай байхаар тооцсон байна. Мөн замын хажуугийн шуудуу, гаргалгаа, салбар шуудуу, уулын шуудуу, хагшаас цуглуулах бассейн зэргийг төсөвлөсөн.


Замын хажуугийн шуудуу

Далангийн хажуугийн шуудуу нь хучилт, хөвөө, ухмал ба далангийн налуугийн усыг зайлуулах үүрэгтэй. Замын хажуугийн шуудуу нь далангийн хажуу талд байрлах ба тэгш тал болон ухмал хэсэгт хажуугийн шуудууг замын хоёр талд, уулархаг эсвэл хэрчигдсэн газарт замын зөвхөн нэг талд төсөвлөсөн байна.



Зураг 3. Төлөвлөж буй трапец хэлбэрийн хажуугийн шуудуу

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө




Зураг 4. Чулуун бэхэлгээ бүхий шуудуу

Шуудууны ёроолын дагуу налууугийн хэмжээ их байгаа хэсэгт шуудуун дахь урсгалын хурд ихэссэнээс шуудуунд угаагдал явагдах магадлалтай. Үүнээс сэргийлж 4%-аас их дагуу налуу бүхий шуудуунд чулуун бэхэлгээ хийхээр болсон байна.


Уулын шуудуу

Уулын шуудуу нь гадаргуугийн усыг цуглуулж залах, усаар зөөгдөж ирсэн хагшаасыг цуглуулж замын байгууламжийг уруй үерээс хамгаалах үүрэгтэй.



Зураг 5. Уулын шуудуу А төрөл


“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 6. Уулын шуудуу Б төрөл

Хагшаас цуглуулах бассейн

Хоолойг огцом налуутай гуу жалгын аманд барих тохиолдолд хоолойн орох хэсэгт уг байгууламжийг төлөвлөдөг байна. Хагшаас цуглуулах бассейн нь усны хурдыг сааруулж, усаар зөөгдөж ирсэн хагшаасыг хуримтлуулж хоолойд цугларахаас хамгаалах бөгөөд хоолойг бөглөрөхөөс хамгаална. Шаардлага бүхий хоолойд энэ байгууламжийг барина.



Зураг 7. Хагшаас цуглуулах бассейн

Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга замын төлөвлөлт

Зам-тээврийн ослыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй техникийн арга хэмжээнд:

- Замд нийлэх боломжийг бүрэн буюу хагас хязгаарлах
- Нэг түвшний уулзвар огтлолцоог цөөлөх
- Төмөр замтай өөр түвшинд огтлолцуулах
- Мал, ан амьтны орц гарцын төлөвлөлт зэрэг орно.

Замын аюулгүй байдлыг хангах дараах асуудлууд зураг төслийн шийдэлд түсгагдах

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ёстой. Үүнд:


- Замын хэвтээ болон босоо тэмдэг тэмдэглэгээг стандарт, норм дүрмийн дагуу тавих
- Тээврийн хэрэгслийн үзэгдэх хамгийн бага зайг зогсох үед 200 м, өөдөөс ирэх хөдөлгөөн 350 м, гүйцэж түрүүлэх үед 680 м-ээр тооцож газрын гадаргатай уялдуулан төсөвлөх
- Дагуу огтлолд гүдгэр босоо муруйн радиус 9000 м, хотгор муруйн радиус 4800 м-ээс багагүй байх
- Дэвсгэр зураг дээрх муруйн радиус 1000 м ба түүнээс бага бол эргэц байгуулж зорчих хэсгийг өргөсгөх
- Зэрлэг ан амьтан, мал, нутгийн зам дээр гарах тохиолдлоос урьдчилан сэргийлэх үүднээс шаардлагатай нүхэн гарцуудыг төлөвлөх гэх мэт.

Замын налуу ба хөндлөн огтлол

Төлөвлөлтийн стандартын дагуу уруу, өгсүүрийн налуугийн хэмжээ 10%-аас хэтрэхгүй байхаар төлөвлөдөг. Замын трассын талбайд 10%-аас давсан налуутай газрууд тохиолдох учир налуу газруудад ухалт хийж, засаж тэгшилнэ.

Цэвдэг, хужирлаг бүхий хөрстэй газраар авто зам төлөвлөх

Төслийн авто зам нь газар нутгийн гадаргуугийн усны зайлуулалт болон чийгшлийн нөхцөлөөр 3-р төрлийн IV-р бүсэд багтана. Сонгосон трассын хувилбар нь гүний болон удаан хугацаагаар (30 дээш хоног) тогтсон гадаргуугийн ус нь гадаргуугийн дээд үеийн чийгшилтэд нөлөөлдөг хагас намагшсан хөрстэй, марз мараа, хужирлаг хөрстэй хэсэг газраар дайран өнгөрдөг. Энэ хэв шинж бүхий хөрс нь төслийн трассын дагуух бүс нутагт ихэнх газраар тархсан боловч замын төлөвлөлтөд тусгай хийц төлөвлөлт шаардахуйц хэмжээтэй нь ховор байна. Марз мараа, хужирлаг бүхий даац муутай хөрстэй хэсэгт хөрсийг нь солих арга хэмжээ авч чулуулаг материалаар даланг хийх шаардлагатай хөндлөн огтлолын зургийг доор үзүүлэв.



Зураг 8. Цэвдэгтэй газар төлөвлөх хөндлөн огтлол

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Авто зам барилгын ажилд хэрэглэгдэх материалын урьдчилсан судалгаа

Цемент: Тус төсөлд 60 цэгт төмөр бетон хоолой, ус давуулах далан, төслийн замыг цемент бетон хучилттайгаар, мөн төслийн замын суурийг цементээр бэхжүүлэх төлөвлөж байгаа учир их хэмжээний цемент шаардлагатай.

Битум: Төслийн авто зам нь хүнд даацын тээврийн хэрэгсэл зорчих зориулалттай бөгөөд замыг цемент бетон хучилттай хийхээр төлөвлөж байгаа юм. Монгол улс битум үйлдвэрлэдэггүй учраас төслийн хүрээнд шаардагдах ОХУ-ын 60/90 маркийн эсвэл АА5НТО стандартын 80/100 маркийн битумыг ашиглах нь технологийн шаардлага хангах боломжтой байна.

Арматур: Төслийн зам барихад нийт 60 цэгт ус зайлуулах хоолой ба цэгт ус давуулах далан, замыг цемент бетон хучилттай барихаар төлөвлөсний дагуу хэрэгцээт арматурыг БНХАУ-аас арматур авах нь эдийн засаг, цаг хугацааны хувьд ашигтай.

Ус: Барилгын ажилд шаардлагатай усны хэмжээг тогтоон Жавхлант Орд ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн нүүрсний уурхайн шүүрлийн уснаас усны хэрэгцээгээ хангах бололцоотой.

Элс: Төлөвлөж буй замын 8 дахь км орчмын хуурай сайранд ашиглагдаж байгаа элснээс авсан дээжүүдийн шинжилгээ том ширхэглэлтэй, уурхайн барилгад ашиглагдаж байгаа элсний дүгнэлт жижиг ширхэглэлтэй гэж гарсан тул барилгын ажлын явцад элсийг шигшиж бэлтгэх, угаах, ширхэглэлийг хольж найруулан хэрэглэх боломжтой. Зам барилгын ажлын үед нийт 662.14 м³ элс шаардлагатай.

Буталсан чулуу: Төслийн авто замын суурь үеийг цементээр бэхжүүлэх бөгөөд цемент бетон хольцонд буталсан чулуу хэрэглэгдэнэ.

Хайрга: Энэ төрлийн ГТАМ материалыг Өмнөговь аймгийн засаг даргын дугаар захирамжаар тогтоосон хайрганы карьерыг ашиглахаар төлөвлөгдөж байна.

Зам барилгын ажлын үед шаардагдах машин механизм тоног төхөөрөмж

Төслийн зам барилгын ажилд 7 нэр төрлийн 35 ш машин механизм, үйлдвэр, тоног төхөөрөмж ашиглагдахаар төлөвлөсөн. Төслийн ажлын нарийн зохион байгуулалт, график төлөвлөлтөөсхамаарч, эдгээр машин механизм, үйлдвэр, тоног төхөөрөмжийн тоонд өөрчлөлт орж болно. Төслийн үед ашиглагдах машин техникийн төрөл, тоо хэмжээг доорх хүснэгтэд тусгав.

Хүснэгт .3: Зам барилгын үед ашиглагдах тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмж	Хүчин чадал	Тоо ширхэг
Хөрс хуулалт			
1	Шанагатай ачигч	3м ³	2
2	Автогрейдэр	-	1
3	Доргиулагч бүхий индүү	18-20 тонн	2
4	Ёнкостой өөрөө шүршигч бүхий усны машин	20 м ³	2
5	Экскаватор	1.3 м ³	1
6	Автосамосвал	20 тонн	2
Далангийн дүүргэлт			
1	Тараах, тэгшлэх, нягтруулахад шанагатай ачигч	3м ³	2
2	Бульдозер	100 тонн	1
3	Доргиулагч бүхий индүү	18-20 тонн	3
4	Ёнкостой өөрөө шүршигч бүхий усны машин	20 м ³	3
5	Экскаватор	1.3 м ³	4

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6	Автосамосвал	20 тонн	2
Ухмалын ажил			
1	Бульдозер	100 тонн	2
2	Экскаватор	1.3 м ³	2
3	Автосамосвал	20 тонн	10
Далангийн дээд үе буюу хүйтэнд тэсвэрлэх үе			
1	Бульдозер	100 тонн	1
2	Экскаватор	1.3 м ³	2
3	Автосамосвал	20 тонн	10
4	Доргиулагч бүхий индүү	18-20 тонн	2
5	Усны машин	20 м ³	2
Цементээр бэхжүүлсэн суурь			
1	Холигч төхөөрөмж	300 тонн	1
2	Автосамосвал	20 тонн	17
3	Хийн дугуйт индүү	20 тонн	2
4	Усны машин	20 м ³	1
5	Укладчик	7 метр өргөнтэй	2
6	Битум цацагч	10 тонн	1
Цемент бетон хучилт			
1	Бетон завод	110 м ³	1
2	Бетон тараах, нягтруурах дэвсэгч	-	4
3	Бетон зөөх миксер	-	
Хөвөө			
1	Экскаватор	1.3 м ³	1
2	Автогрейдэр	-	1
3	Доргиулагч бүхий индүү	18-20 тонн	2
4	Усны машин	20 м ³	1
5	Автосамосвал	20 тонн	6

Зам барилгын ажлын үргэлжлэх хугацаа

“Жавхлант-Орд” ХХК-ийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай-Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох авто зам барих төслийг жилийн 4 сарын 15 наас 5, 6, 7, 8, 9, 10, 11 сар дуустал буюу 7 сарын хугацаанд хийхээр төлөвлөсөн бөгөөд календарийн хоногоор жилд 250 өдөр зам барилгын ажил үргэлжлэхээр байна. Зам барилгын ажлыг 2 ээлжээр хийнэ гэж тооцоход ажил үргэлжлэх хугацаа өглөөний 6-аас оройн 10 цаг буюу ашигтай ажиллах хугацаа 12-13 цаг болж 2 жилийн хугацаанд зам барилгын ажлыг бүрэн дуусгахаар ТЭЗҮ-д төлөвлөгдсөн байна.

Хүснэгт 4: Зам барилгын ажлын төлөвлөгөө

№	Ажлын нэр	Жилийн саруудад хийгдэх ажлууд							
		4	5	6	7	8	9	10	11
1	Бэлтгэл ажил								
2	Трасс сэргээх								
3	Хөрс хуулах								
4	Далан								
5	Ердийн ухмал								
6	Хатуу ухмал								
7	Далангийн дээд үе								
8	Цементээр бэхжүүлсэн суурь								
9	Хөвөө								
10	Цемент бетон хучилт								
11	Гүүрүүд								

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

12	Хиймэл байгууламжууд								
13	Өарийн шуудуу								
14	Уулын шуудуу								
15	Нөхөн сэргээлт								
16	Босоо тэмдэг								
17	Хэвтээ тэмдэглэгээ								
18	Дохионы шон								
19	Заслын ажил								

Зам барилгын үед ажиллах хүч

Уг замын төсөлд инженер техникийн ажилчид, механикч, жолооч, туслах ажилчин нийлээд 1 гүйцэтгэгч, 4 бие даасан бригад буюу нийт 60 хүн ажиллахаар байна.

Төслийн ус ашиглалт

Төслийн ус ашиглалтын тооцоог БОНХАЖ-ын сайдын 2015 оны 7 сарын 30-ний өдрийн А/301 тоотгушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 7 дугаар хавсралтаар баталсан Авто замын салбарын усны норм, 12 дугаар хавсралтаар баталсан орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм болон 13 дугаар хавсралтаар баталсан зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм ашиглан ус ашиглалтын тооцоог хийв.

Зам барилгын ажлын болон зам усалгааны усыг нүүрсний уурхайн шүүрлийн уснаас хангана. Төслийн авто замын барилгын ажил болон зам усалгааны ажилд жилд 18806.8 м³ ус ашиглахаар байгаа нь энэхүү усны хэрэглээг уурхайн шүүрлийн уснаас хангах бүрэн боломжтой байна. Харин ажилчдын унд ахуйн усны хэрэглээг гидрогеологийн хайгуулаар тогтоогдсон уурхайн 2 гүний худгийн усаар хангана. Уурхайд байрлах худгийн ундарга нь 3.2 л/с, цооногийн гүн 64.5 м байна. Төслийн авто замын барилгын ажлын хугацаанд нийт 600 м³ буюу өдөрт 1.2 м³ усыг унд ахуйд ашиглахаар байна. Ийнхүү өдөрт ашиглах усны дээд хэмжээ нь 0.014 л/сек тул уурхайд байрлах худгаас ажилчдын унд ахуйн усыг хангахад хүрэлцэхээр байна.

Хүснэгт 5: Ус ашиглалтын тооцоо

Зориулалт	Ажлын хэмжээ	Тоо хэмжээ	Норм	Тооцоолол
Зам барилгын ажил	Суурийн доод үе байгуулах	39,380 м ³	0.10 м ³	3,938 м ³
	Цементээр бэхжүүлсэн суурь байгуулах	39,380 м ³	0.05 м ³	1,969 м ³
	Цемент бетон хучилт хийх	33,473 м ³	0.45 м ³	15,062 м ³
	Хайрган хөвөө хийх	16110 м ³	0.009 м ³	1,449 м ³
	Нийт ашиглах ус		22,418 м³	
Унд ахуйн зориулалт Зам талбайн усалгаа	Ажилтны унд ахуйд хэрэглэх ус 250 хоног	60 ажилтан	20 л/хоног	600 м ³
	Түр замыг услах болон ногоон байгууламж (1 удаа*7хоногт*жил) (17.9 км, бм-н өргөнтэй)	107400 м ²	2 л/м ²	15,465.6 м ³
НИЙТ АШИГЛАХ УС				38,483.6 м³

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр болох Өмнөговь аймгийн Гурвантэс сум нь байгалийн бүс бүслүүрийн хувьд ДТД 1140-2769 метрт өргөгдсөн уулс, говь тал, хөндий хоолойнууд бүхий цөлөрхөг бүсэд оршино.

Уур амьсгал эрс тэс, ширүүн, хуурай, дулаанаас хүйтэвтэр хосолсон шинжтэй, өвөлдөө хүйтэвтэр зун нь аагим халуун, хавартаа салхи шуурга ихтэй.

Жилийн дундаж температур 4,0°C -4,6°C, салхины дундаж хурд 3,6 м/с байна. Хур тунадасны жилийн хэмжээ 100 мм-ээс хэтэрдэггүй.

Хүн амын нягтшил бага (1км-т 0.2 хүн) , 5291 хүн амтай, 27900 км/кв газар нутагтай.

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн 5 багтай. Ерөнхий боловсролын 12 жилийн сургууль, эрүүл мэндийн төв, цэцэрлэг, соёлын төв гэх мэт төр төсвийн байгууллага, худалдаа үйлчилгээний чиглэлийн болон уул уурхайн ААНБ-ууд үйл ажиллагаа явуулдаг. 2023 оны жилийн эцсийн байдлаар 173603 толгой мал тоологдсон. 649 малчин өрхтэй.

Физик-газарзүй

Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн мужид багтах бөгөөд өргөргийн дагуу сунаж тогтсон байрлалтай, Хуцын булаг, Навтгар уул, Улаан нуурын зэрэг олон тооны хотгорууд намхавтар дов, толгод, ухаа гүвээ болон голчлон хойноос урагшаа чиглэлтэй хэдэн км-ээс хэдэн арван км үргэлжилсэн нилээд олон тооны шигүү хуурай сайр, хоолой хөндийнүүдтэй.

Төв азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд багтдаг. Тухайн жил, улирлын цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай, заримдаа гандаж ширгэдэг. Талбайд янз бүрийн хэлбэртэй, олон тооны хэдэн зуун м-ээс хэдэн арван км үргэлжлэх хуурай сайрууд тохиолддог. Цас их орж хайлах, үргэлжилсэн бороотой үед эдгээр сайрууд урсгал ширүүнтэй гол болж, бороо татрахад усгүй болно. Хур бороотой үед жижиг хонхор, хотгор газарт жижиг нуурууд бий болох ба тэдгээр нь элс булингартай усаар дүүрч хэдэн долоо хоног, заримдаа хэдэн сар устай байдаг. Тогтмол устай гол, горхигүй ба булаг, шанд нилээд тохиолддог. Эдгээр нь хэдэн м урсаад элсэн доогуур шургадаг. Хүн малын ундны усанд худгийн ус хэрэглэх бөгөөд худгуудыг голчлон дөрөвдөгчийн хурдаст хуурай сайр, нуурын зах хавийг бараадуулан гаргасан байдаг. Худгийн түвшин нь 1-2м, заримдаа 5-7м байдаг.

Хөрс

Говийн бор хөрс болон цөлийн карбонатлаг бор саарал хөрс зонхилон тархсан байдаг. Говийн бор хөрс сайр чулуу, элс шавранцар хурдсаас тогтоно. Энэ хөрс нь нимгэн давхаргатай ялзмагийн зүйлээр бага боловч эрдэс давс агуулсан. Ховор тохиолдолд нуур тойрмын зах хэсгээр хужир, марзтай хөрс тохиолдоно. Түр зуурын ус тогтдог хотгоруудад шаварлаг хөрс үүссэн байдаг. Хуурай сайрын хөндий болон тэгш талд элсэрхэг хөрс тархсан байдаг.

Ургамал

Ургамлын хувьд тачир сийрэг бөгөөд газрын хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээр ургана. Ихэвчлэн бутлаг ургамал ургах бөгөөд энэ нь дотроо зэрлэг буйлс, өргөст сундуй гэх мэт янз бүр байна. Хонхорт буюу сайрын хоёр талаар хайлаас ургасан байх ба агь, шарилж, харгана зэрэг нь цав толгодуудыг бүрхсэн байна. Заг нам дор

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

газар элсэрхэг хөрсөнд их хэмжээтэй ургадаг. Ус чийг багатай салхи ихтэй учир ургамлын бүрхүүл сийрэг байдаг боловч гэжээлийн сайн чанартай ургамлаар нилээд баялаг.

Амьтан

Ан амьтдын тоо, төрөл зүйн хувьд их тааламжтай. Туурайтнуудаас зээр, хулан, хар сүүлт, уулархаг газар аргаль, янгир махчин амьтдаас чоно, үнэг, хярс, мэргэчдээс туулай, алагдаахай, хулгана, бозлог хэвлээр явагчдаас гүрвэл, могой, шавьжнаас аалз, арваалж, хилэнц, жигүүртнээс болжмор, бүргэд, харцага, тас амьдарна.

Уур амьсгал

Халуун зунтай, хуурай муж, цасгүй зөөлөвтөр өвөлтэй дэд мужид хамрагддаг.

1-р сарын агаарын дундаж температур -15-18 хэм, 7-р сарын агаарын дундаж температур +20+25 хэм бөгөөд хамгийн их халуун нь 7-р сард +41 хэм хүрдэг байна.

Ус чийг багатай учир манан бараг ажиглагддаггүй, хурд тунадасны хэмжээ жилд 100мм-ээс бага бөгөөд түүний 80% нь 7-8-р сард унадаг. Жилийн салхины дундаж хурд 4м/с бөгөөд жилд дунджаар 30-35 хоног 15 м/с хүртэл хүчтэй цасан болон шороон шуургатай өдрүүд тохиолдоно.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хатуу хучилттай зам тавих ажлын байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойллоо.

Агаарын чанарт: Машин техникийн хөдөлгөөнөөр тоосжилт, утаа үүсэх магадлалтай.

Газрын хэвлийд: Замын далан, гүүр, хоолойн бүтээн байгуулалтын ажлын шууд болон дам нөлөөгөөр газрын хэвлийд эвдрэл үүснэ.

Гадаргын болон газрын доорх ус: Зам барилгын ажил, ахуйн хэрэгцээнд ашиглах усны эх үүсвэр болон, төслийн талбайд байрлах уст цэгүүдийн чанар, нөөцөд тодорхой нөлөө үзүүлж болзошгүй.

Хөрс: Автомашины хөдөлгөөнөөр олон салаа зам үүсгэх зэрэг нь тухайн орчны хөрсөн бүрхэвчийг элэгдэл эвдрэлд оруулах шууд нөлөө болно.

Ургамал: Үйл ажиллагааны шууд болон дам нөлөөнд өртөх талбайн ургамлын төрөл зүйл хөндөгдөнө.

Амьтан: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, машин техникийн дуу чимээ зэргийн нөлөөгөөр зэрлэг амьтад үргэж дайжих, тархац нутаг хумигдах магадлалтай.

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийн түвшин

Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд	Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийн түвшин		
Агаарын чанар		дунд	
Газрын хэвлий		дунд	
Гадаргын ус			Бага
Газрын доорх ус			Бага
Хөрс		дунд	
Ургамал		дунд	
Амьтны аймаг	Их		

“Жавхлант Орд” ХХК-ийн Зангат-Уул 1 төслийн Баянтолгой нүүрсний уурхайгаас Хотгорын нүүрсний уурхай Нарийнсухайт чиглэлийн авто замтай холбогдох 17.9 км хатуу хучилттай авто зам барих төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчим баримтлан ажиллана.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш БОНБ үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгож ажиллана.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг тооцсон болно.

БОМТ-г “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу хийж гүйцэтгэсэн.

